



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ139-17

Нэмэлт, өөрчлөлт 1 (1)

Аэродромын хэрэглэгчдийн бүлэг

2022 оны 12 сарын 09

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын зөвлөмжийн цуврал (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Зорилго

Энэ АС нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид хэрэглэгчийн бүлгийг байгуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахад холбогдох зааварчилгаар хангах бөгөөд шаардлагатай нөхцөлд хэрэглэгчийн бүлгийг илүү үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болно.

Холбогдох дүрэм

Байхгүй

Өөрчлөлтийн тэмдэглэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

АС139-17-г монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

АС139-17-г NZ АС139-17-гийн 2012 оны 7 сарын 20-ний өөрчлөлт 0-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

Танилцуулга	3
Хэрэглэгчийн бүлгийн бүрэлдэхүүн	4
Хэрэглэгчийн бүлгийн үйл ажиллагаа.....	4
Ерөнхий зүйл	4
Хэрэглэгчийн бүлгийг байгуулах	4
Давтамж.....	5
Хөтөлбөр.....	5
Авах арга хэмжээ	5
Хурлын тэмдэглэл.....	6
Нисэхийн судалгаа	6

Танилцуулга

Аэродромын хэрэглэгчид тогтмол уулзаж тулгамдсан асуудал, аливаа өөрчлөлтүүдийг хянах, баталгаажуулах, аюулгүй байдлыг сайжруулах зорилтыг хамтдаа хэлэлцэж эхэлснээр аэродромын аюулгүй ажиллагаа эрс дээшилдэг. Аэродромд мэдээлэгдсэн нисэхийн холбоотой олон тооны асуудал болон осол зөрчлийг аэродромын үйл ажиллагаа эрхлэгч аэродромын хэрэглэгчдийн бүлэг байгуулж ашигласнаар багассан гэдэг нь түршлагаар батлагдсан болно. Энэ нь аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг таньж тогтоох, аэродромын ашиглалтанд ямар нэгэн үйл ажиллагааны нөхцөл болон хязгаарлалтыг тогтоох хэлбэр юм.

ИНЕГ нь аэродром бүрд аэродромын хэрэглэгчийн бүлгийг бүрдүүлэх болон хэрэглэхийг хүчтэйгээр дэмждэг. Аэродром болон орчмын агаарын зайн үйл ажиллагаанд оролцон ажилладаг бүлэг хүмүүсийн дуу хоолойгоор илэрхийлэгдэж буй тулгамдсан асуудал болон холбогдох зөвлөмжийг маш нухацтайгаар хүлээж авдаг.

Аэродромын хэрэглэгчдийн бүлэг нь аэродромын хэрэглэгчдээс илэрхийлсэн аюулгүй байдлын асуудалд анхаарал хандуулах хамгийн шилдэг хэлбэр бөгөөд ямар нэгэн төлөвлөгдсөн өөрчлөлт нь аэродромын орчимд үзүүлэх нөлөөлөл, аэродром дээр явагдаж байгаа үйл ажиллагааны төрөл, шаардлагатай үед AIP-д зарласан үйл ажиллагааны нөхцөлийг хянах, шинэчлэх зэрэг асуудлыг хэлэлцдэг.

Хэрэглэгчийн бүлгийн зорилго нь аэродромын болон түүний агаарын зайн ашиглалтын аюулгүй ажиллагааны процедурын зохицуулалт, боловсруулалтыг дэмжих юм. Гол зорилго нь аэродром дээр үйл ажиллагаа эрхлэгчид өөрсдийн үйл ажиллагааны төрөл болон тодорхой бүсэд тохирсон процедурыг эзэмших, ашиглах явдал юм. Энэ нь “Оролцогчийн үүрэг хариуцлага” гэж бас тодорхойлогддог.

Энэ нь аэродром ашиглалтын аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны бас нэгэн чухал бүрдэл юм.

АС-ын зорилго нь аэродромын хэрэглэгчийн бүлгийг байгуулах, үйл ажиллагааг явуулахад холбогдох зааварчилгаагаар хангахад оршино. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөгч нь шаардлагатай бол туслалцаа үзүүлэх боломжтой байдаг. ИНЕГ-ын НААХЗА-тай холбоо тогтоох вэб хуудсыг дор үзүүлэв.

<http://mcaa.gov.mn>

Хэрэглэгчийн бүлгийн бүрэлдэхүүн

Аэродромтой холбоотой ашиглалтын ажлын бүтээмж, тогтмолжилт, аюулгүй байдалд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулдаг бүх хүмүүс болон байгууллагын төлөөллийг аэродромын хэрэглэгчдийн бүлэгт багтаасан байвал зохино. Дараах төлөөлөл нь бүрэлдэхүүнд багтана:

- хуваарьт нислэг бүхий агаарын тээвэрлэгч
- орон нутгийн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч
- нисдэг тэргээр үйл ажиллагаа эрхлэгч
- нислэгийн сургууль
- агаарын тээвэрлэгчдийн холбоо
- нисэх төхөөрөмжийн клуб
- делтаплан клуб
- шүхрийн байгууллага
- нисэх загварын клуб
- гадны гэрээт байгууллага /өвс хадах, зэрлэг устгах, зам талбай засварлах гэх мэт/
- НААХЗА-ны аюулгүй байдлын зөвлөгч болон бусад ажилтан

Дээрх бүх байгууллага нь өөрсдийн ямар нэгэн хэрэгцээ шаардлагатай бөгөөд бусдын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц зүйлсийг нийцүүлж ажиллах шаардлагатай. Хэрэв эдгээр хэрэгцээ болон үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн бүлэгт хэвшсэн бөгөөд аэродромын үйл ажиллагаа явуулах зөвшилцөл бий болсон үед аюулгүй байдал, ажлын бүтээмж нэмэгдэх сайн талтай.

Хэрэглэгчийн бүлгийн үйл ажиллагаа

Ерөнхий зүйл

Иргэний нисэхийн салбарт маш олон хэрэглэгчийн бүлгийн үр дүнтэй үйл ажиллагаа байдаг бөгөөд нэг чиглэлд 2 өөр бүлэг байдаггүй болно. Эдгээр нь аэродромын тодорхой орчинд үйл ажиллагаа нь хамгийн сайн нийцсэн байгууллага болсон байдаг.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь эцсийн дүндээ аюулгүй ажиллагааны хамгийн гол хариуцлагыг хүлээх бөгөөд нислэгийн үйл ажиллагааны нөхцөл болон хязгаарлалтыг тогтоох, зарлах үүрэгтэй. Гэвч дээрх үйл ажиллагааг зохицуулах үүрэг нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс илүү нислэгийн үйл ажиллагааны түршлага, мэргэжил бүхий аэродром дээр үйл ажиллагаа явуулдаг бусад үйл ажиллагаа эрхлэгчид ихэвчлэн шилждэг.

Хэрэглэгчийн бүлгийг байгуулах

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь холбогдох бүх ажилтныг урьж анхны уулзалтыг зохион байгуулах хэрэгтэй. Хүсэлт гаргасан тохиолдолд ИНЕГ-ын аюулгүй байдлын зөвлөгч холбогдох зааварчилгааг өгөх үүрэгтэй. Хэрэглэгчийн бүлгийн зорилго нь тодорхой тайлбарлагдаж, оролцогч нь аюулгүй байдал болон агаарын хөлгийн үйл ажиллагаа тогтмолжилтыг сайжруулж болох боломжтой газарт зочилж танилцана.

Эдгээр яригдсан зүйлсийн дагуу ямар нэгэн хүн хэрэглэгчийн бүлгийн даргаар сонгогдох шаардлагатай бөгөөд энэ нь заавал аэродромын үйл ажиллагаа эрхлэгч байх албагүй. Хэрэглэгчийн бүлгийн дараагийн уулзалтын тов, үүссэн асуудлыг шийдвэрлэх, засах ажлын төлөвлөгөө батлагдсан байвал зохино.

Давтамж

Хэрэглэгчийн бүлгийн уулзалт нь аэродромын үйл ажиллагааны зэрэглэл, нөхцөлөөс хамаарч тодорхой хугацааны давтамжтайгаар товлогдсон байна. Хэрэв аэродромын зэрэглэл болон нөхцөл нь өндөр бол уулзалтыг жилд 6-аас доошгүй удаа товлон. Аэродром нь зөвхөн нэг хуваарьт нислэгтэй үед жилд 2 удаа уулзах нь зохимжтой.

Аэродром дээр шинэ үйл ажиллагаа эрхлэгч болон шинэ ашиглалтын нөхцөл зарлагдах, ноцтой асуудал үүсэх, осол, зөрчил гарах үед тусгай уулзалтыг зохион байгуулна.

Хөтөлбөр

Уулзалт бүрийн өмнө хөтөлбөр тодорхой болсон байх ба хэрэглэгчийн бүлгийн гишүүн бүрд тараагдсан байна. Энэхүү хөтөлбөр нь тухайн уулзалтын стандарт байх бөгөөд зөвхөн шаардлагатай тохиолдолд өөрчлөлт хийгдэнэ.

Хэрэглэгчийн бүлгийн уулзалтанд яригдах асуудал:

- нисэх буудлын үйл ажиллагааны асуудал
- аэродромын төлөвлөгөөнд орох өөрчлөлт болох хийхээр төлөвлөсөн ажил
- агаарын зайн асуудал
- аюулгүй байдалтай холбоотой зөрчил, эсхүл ослын хяналт
- AIP дэх аэродромын зарлагдсан мэдээлэл, үйл ажиллагааны журмын хяналт
- агаарын зайн ямар нэгэн төлөвлөлтийн өөрчлөлтийн зохицуулалт болон хяналт
- тусгай хэрэгцээт байгууллагад зохицсон нислэгийн хөдөлгөөний дүрмийн шаардлага. Делтаплан, нисдэг тэрэгний сургалт, нисэх загвар г.м.
- аэродромын үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц ямар нэгэн төрлийн үйл ажиллагааг эхлүүлэх болон дуусгах.
- өмнө нь тусгай журмаар боловсруулсан болон цаашид үргэлжлэхгүй үйл ажиллагаа
- бүлгийн аль нэг гишүүний дэвшүүлсэн асуудал

Авах арга хэмжээ

Ямар нэгэн асуудал үүсээд түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөсөн бол аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь дээрх төлөвлөсөн ажил нь ИНД-139 болон иргэний нисэхийн буусад хууль, дүрмийн холбогдох заалтыг зөрчөөгүй, эсхүл ИНД-139-ийн дагалдах баримт бичигтэй харшлахгүй болохыг бататгах үүрэгтэй.

Төлөвлөсний дагуу авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд асуудал үүссэн бол аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь арга хэмжээг авахаас өмнө ИНЕГ-тай зөвшилцөх үүрэгтэй.

Хурлын тэмдэглэл

Ирээдүйд хэрэглэх баримт болгон хадгалах зорилгоор уулзалт бүр дээр хурлын тэмдэглэл хөтөлсөн байна. Авах арга хэмжээ зөвшөөрөгдөж, холбогдох шийдвэр гарсан үед хурлын тэмдэглэл дээр гарсан шийдвэр болон дараагийн авах арга хэмжээг хэн хариуцахыг тодорхой тэмдэглэнэ. Хурлын тэмдэглэл нь бүлгийн гишүүн бүрд аль болох хурдан тараагдах бөгөөд дараагийн уулзалтаар гишүүд ямар нэгэн шаардлагатай арга хэмжээ авах боломжтой эсэхийг баталгаажуулна.

Нисэхийн судалгаа

Нисэхийн судалгаа нь аэродром болон агаарын зайн үйл явц болон аюулгүй байдлын шаардлага бүрэн тавигдсан эсэхийг баталгаажуулах хяналтын хэрэгсэл юм. Хэрэглэгчийн бүлгийн гишүүд нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид аэродромын орчинд ямар нэгэн өөрчлөлт хийхээр төлөвлөх үед тусалснаар нисэхийн судалгаа, аюулгүй байдлын хяналт хийхэд туслах болно.

АС139-5 аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон бусад хүмүүс нисэхийн судалгааны ажлыг гүцэтгэхэд гарын авлага, холбогдох мэдээллээр хангадаг.

--oOo--